

Увс аймгийн ОУИТБС-ын дэд зөвлөлийн
2024 оны үйл ажиллагааны тайлан

Зорилт 1. Судалгаа, тайлан мэдээ гаргах, сургалт зохион байгуулах.

1.1 Дэд зөвлөлийн хурал зохион байгуулах

Дэд зөвлөлийн 2024 оны ажлын төлөвлөгөөний хүрээнд 19 сумын байгаль орчны мэргэжилтэн, байцаагч, хамгаалагч нарт 2024 оны 04 дүгээр сард 10-ны өдөр анхны зөвлөгөөнийг зохион байгуулсан. Уг арга хэмжээнд нийт 200 гаруй иргэн, аж ахуй нэгжийн төлөөллүүд оролцов.



Дэд зөвлөлийн 2-р ээлжит хуралдааныг 09 дүгээр сарын 15-ны өдөр Увс аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын алба болон Аймгийн Засаг даргын Тамгын газар, Байгаль орчны газартай хамтран аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг Уул уурхайн хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгжүүдийг оролцуулсан “Хариуцлагтай Уул уурхайчид” зөвлөгөөнийг зохион байгуулсан. Уг арга хэмжээнээс гарсан санал санаачилгыг зөвлөмжөөр аж ахуй нэгжид хүргэж хамтран ажилласан.



Уул уурхайн салбараас баримталж буй бодлого, шийдвэрийн талаар аймгийн Байгаль орчны газар, Эрүүл мэндийн газар, Улаан загалмайн хороо, Бор аварга сан, Увсын Эрэгтэйчүүдийн холбоо ТББ-аас хамтран үйл ажиллагаа явуулдаг уул уурхай компаниудын төлөөлөлд сургалт, мэдээлэл хийж эрчүүдийн санал хүсэлтийг сонсох хэлэлцүүлэг хийж, 9 асуудлаар зөвлөмж гарган хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг хугацаанд нь хүргүүлсэн.

Засгийн газрын 2022 оны 295 дугаар тогтоол гарсантай холбогдуулан баруун бүсийн төлөөлөгчийн газар нь Ховд аймагт төвлөрөн хэвийн үйл ажиллагаа явуулж байна. Төлөөлөгчийн газраас шаардсан мэдээ, судалгааг гаргаж өгч хамтран ажиллаж байна.


2024 онд Увс аймгийн хэмжээнд 10 ААН хэвийн үйл ажиллагаа явуулж газар, ус, хогны хураамжийг жил бүр төрийн сангийн дансанд тушааж тайлан мэдээгээ сум орон нутгийн иргэдийн хуралд тайлагнах, орон нутгийн телевиз, сонин, сайт, хэвлэл мэдээллийн байгууллагуудаар дамжуулан иргэдэд нийт 5 удаа хүргэн ажилласан. Мөн Бөхмөрөн суманд Хотгор ХХК 3 багийн 516 өрхөд 2Тн нүүрс, ЗДТГ-т 20сая, Эрчим ХХК Хар алтат багийн 176 өрхөд 3Тн нүүрс, ЗДТГ-т 10сая, Шинэст өргөө ХХК Тариалан сумын ЗДТГ-т 15сая, Жэй Си Си АР ХХК 20сая тус тус хандивласан.

Чадавхжуулах сургалт зөвлөгөөн:

2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр Аж үйлдвэр эрдэс баялгийн яамнаас зохион байгуулсан “Бичил уурхайчдын нэгдсэн” зөвлөгөөнд Увс аймгийн удирдлагууд холбогдох мэргэжилтэн, Давст, Тариалан сумдын бичил уурхайчдын төлөөлөл 10 нөхөрлөлийн ахлагч, гишүүдийг хамруулж оролцсон.



Зорилт 2: Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгжийн тайланг сонсох, сумдын эвдэрсэн газрын мэдээллийг нарийвчлан хийх сургалт хэлэлцүүлэг зохион байгуулах.



Засгийн газрын 2016 оны 179 дүгээр тогтоолоор баталсан Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх ажлын байр нэмэгдүүлэх гэрээний загварын дагуу Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгжүүдээс, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч "Шинэст өргөө ХХК, "Хартавагатай", "Хотгор", "Эрчим уурхай /нүүрсний/", Төмрийн хүдрийн "Эй Эл Жи Ти", ТТАМ-ын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч "Чандмань Уулын хишиг", "Нэтэнт, "Энержи Импайр", зэрэг аж ахуй нэгжүүд үйл ажиллагаа явуулдаг харьяа ЗДТГ-тай хамтран ажиллах гэрээг байгуулж, талууд үүрэг хүлээн, хамтран ажилласан. Дээрх аж ахуйн нэгжүүдээс Эрчим, Эй Эл Жи Ти, Хартарвагатай, Хотгор компаниуд гэрээг 90- ээс дээш хувьтай дүгнүүлсэн.

Зорилт 3:Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд:

Монгол улсын Ерөнхийлөгчийн 58 дугаар зарлигийн хүрээнд "Тэрбум мод" үндэсний хөтөлбөрийн хүрээнд: Эй Эл Жи Ти ХХК Наранбулаг суманд 0.6 га талбайд 610 ш, Хотгор ХХК 600 ш бургас тус тус тарьсан.

Нийт: 2024онд 1210ш мод тарьсан /УУсалбарын ТЗ эзэмшигч/



Хууль тогтоомж тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах:

Аймгийн ЗДТГазар, БОАЖГазар Улаангом, Тариалан, Түргэн сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч, Цагдаагийн газрын экологийн цагдаатай хамтран аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн төлөөллийг оролцуулан “ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулж. Хэлэлцэн гарсан санал, хүсэлтийг нэгтгэн чиглэл, зөвлөмж боловсруулан тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, сумын Засаг дарга нарт хүргүүлсэн. Мөн “Нөхөн сэргээлт-2024” арга хэмжээг эрчимжүүлэх, эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг үр дүнтэй зохион байгуулах талаар үүрэг даалгавар өгсний хүрээнд байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, уул уурхайн компаниудын нийгмийн хариуцлагыг идэвхжүүлэх зорилгоор “Нөхөн сэргээлт- Ногоон тал 2024” challenge аяныг БОАЖГ-аас санаачлан зохион байгуулж ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Хотгор ХХК, Эрчимбаян-Өлгий ХК, Жамц давс ХХК, түгээмэл тархацтай ашигт малтмалын чиглэлээр Тоосгон уул ХХК, Энержи Импейр ХХК, Чандмань уулын хишиг ХХК, Нэтэнт ХХК, Эй Эл жи ти ХХК – уудад аяны удирдамж, чиглэлийг хүргүүлэн хамтран ажиллаж байна.

2024 оны тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасны дагуу “Хотгор” ХХК- 0,74 га, “Хар тарвагатай” ХК- 1,2 га, “Нэтэнт”- 5 га, бичил уурхайн чиглэлээр “Жамц давс эрдэнэ” нөхөрлөл 0.52 га техникийн нөхөн сэргээлт хийсэн. Нийт 7.46 га талбайг нөхөн сэргээсэн. Дээрх аж

ахуй нэгжийн уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн мэдээг <https://www.eic.mn/> мэдээллийн санд шивж орууллаа. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгжүүдээс, нүүрсний ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч "Хартавагатай", "Хотгор", "Эрчим уурхай", Төмрийн хүдрийн "Эй Эл Жи Ти" мөн ТТАМ-ын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч "Чандмань Уулын хишиг", "Нэтэнт, "Энержи Импайр", зэрэг аж ахуй нэгжүүд Тариалан, Бөхмөрөн, Улаангом, Наранбулаг сумын ЗДТГ-тай хамтран ажиллах гэрээг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд байгуулсан.

Зорилт 2. Иргэдэд нээлттэй ил тод байдлыг таниулах, хяналт шалгалтыг зохион байгуулах

Аж үйлдвэр эрдэс баялгийн яамны салбарын хяналтын газраас Увс аймгийн 24 объектод хяналт шалгалт хийхээр төлөвлөснөөс хамтарсан хяналт шалгалтыг 23 аж ахуйн нэгжид хийж, 1 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулаагүйгээс хяналт шалгалт хийгдээгүй болно. Илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 11 улсын байцаагчийн хугацаатай албан шаардлагыг аж ахуйн нэгжид хүргүүлж, биелэлтийг гаргуулж байна. Энэ онд шинээр байцаагчийн эрх олгоогүй.

Бөхмөрөн сумын Хотгор ХХК-ийн уурхайд




Аймгийн хэмжээнд хууль бусаар алт олборлох явдал 2024 онд гараагүй. Өнөөдрийн байдлаар Тариалан сумын Бор хавцалд бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын хүрээнд 4 нөхөрлөлийн 30 гаруй иргэн ажиллаж байна. Бусад сумын сэжигтэй цэгт аймгийн экологийн цагдаа болон мэргэжлийн байгууллага сум орон нутгийн албан хаагчид тогтмол хяналт тавин ажиллаж байна. /Хууль бусаар алт олборлох тохиолдол гараагүй/





**Аймгийн хэмжээнд хяналт шалгалт хийсэн ОУИТБС-ийн дэд зөвлөлийн
бүрэлдэхүүн**



Тайлан гаргасан:
ОУИТБС-ын Увс аймгийн дэд зөвлөлийн

Нарийн бичгийн дарга / Т.Төвсанаа/